



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/235

Хэрлэн сум

Аймгийн “Хөдөлмөр нийгмийн
түншлэлийн гурван талт хороо”-ны
бүрэлдэхүүн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Нутгийн захиргааны байгууллага, ажилтны болон ажил олгогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах аймгийн “Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо”-ны бүрэлдэхүүнийг дараах байдлаар баталсугай.

Дарга: Аймгийн Засаг даргын орлогч
Дэд дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Гишүүд: АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга
Аймгийн Ажил олгогч эздийн холбооны тэргүүн
Аймгийн Худалдаа, аж үйлдвэрийн танхим дарга

Нарийн бичгийн дарга: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

2.Аймгийн “хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо”-ны үйл ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хорооны даргад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ